

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-24

- 1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох** 4-24
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны
06 дугаар сарын 02-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Ч.Анар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Баатархүү, П.Ганзориг.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох асуудлыг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

Ч.Анар: Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	0
Бүгд:	5

100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ, шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох асуудлыг хаалттай горимоор хэлэлцэхээр тогтов./13:21/

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, мөн яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав, мөн газрын Цахим шилжилтийн төсөл, хөтөлбөрийн бүртгэл, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа, Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер Д.Очирсүрэн, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл технологи, систем нэгтгэлийн газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Х.Шижирмөнх нар байлцав.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэдээллийг Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мягмарнаран, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл технологи, систем нэгтгэлийн газрын дарга Б.Билэгдэмбэрэл нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Ж.Золжаргал, Ч.Анар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны нээлттэй хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 14 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Ч.АНАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Анар: Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Чинбаатарын Анар ирсэн байна. Ренчиндоржийн Батболд ирсэн байна. Батбаярын Жаргалан ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн ирж, ирц 72 хувьтай бүрдсэнээр хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

2.Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн хүрээнд Монгол Улсад үр өгөөжтэй ашиглах боломжтой олон талт хэрэгцээ шаардлагад нийцсэн хиймэл дагуулын талаар судлан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу. Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Дэд хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.3 дугаар заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 8.3 дахь заалтыг үндэслэн 2 дахь асуудлыг хаалттай хэлэлцэх саналтай байна.

Ч.Анар: Хэлэлцэх асуудлын 2 дугаар асуудлыг хаалттай хэлэлцэх горимын саналыг Соронзонболд гишүүн гаргасан байна. Соронзонболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт. Санал хураалтад бэлдье. Соронзонболд гишүүний гаргасан 2 дахь асуудлыг хаалттай хэлэлцэх горимын саналын талаарх санал хураалт. Цэнгүүн гишүүн дэмжсэнээр бүртгүүлж байна. Хуралдаанд нийт 5 гишүүн оролцсоноос 5 гишүүн буюу 100 хувийн дэмжсэнээр 2 дахь асуудлыг хаалттай хэлэлцэхээр боллоо.

Хэлэлцэх асуудал 1.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсоно.

Ажлын хэсгийнхнийг оруулъя. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой дэд хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Б.Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга ирсэн байна. З.Цэдэнжав Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч ирсэн үү. Арай ирээгүй байна. Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга ирсэн байна. Б.Билэгдэмбэрэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл технологи, систем нэгтгэлийн газрын дарга ирсэн байна. Д.Цэнгүүнжав Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга ирсэн байна. Э.Болормаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахим шилжилтийн төсөл хөтөлбөрийн бүртгэл, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн ирсэн байна. Л.Эрдэнэчулуун Бодлого, төлөвлөлт, инновацын газрын Төлөвлөлт тайлагналын менежер ирсэн үү. Ирсэн байна. Л.Эрдэнэчулуун ирсэн үү. Ирсэн байна. Д.Очирсүрэн Тусгай чиг үүргийн аудитын газрын аудитын менежер ирсэн байна. Б.Ганзориг Сангийн яамны Хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга ирсэн байна. Ж.Алтантуяа Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч ирсэн байна.

Ингээд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны сайд яасан билээ. Гишүүдэд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бэлтгэж ирүүлсэн мэдээллийг тараасан байгаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цэнгүүнжав танилцуулж, мэдээлэл хийнэ. Индрийн микрофон.

Д.Цэнгүүнжав: Хүрэлцэн ирсэн бүх гишүүд болон бусад төлөөлөгчдөд бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Танилцуулгыг эхэлье.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцын харьяа байгууллагуудын мэдээлэл технологийн чиглэлээрх төсөл, арга хэмжээнд 2022-2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 тэрбум, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хүрээнд 54 тэрбум, урсгал төсөв, өөрийн хөрөнгөөр 11 тэрбум, Засгийн газрын нөөц хөрөнгөөр 1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, холбогдох төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Нийт хөрөнгө 84 тэрбум. Графикаар 2 дахь хуудсанд харуулсан байна.

Ч.Анар: Танилцуулгаа хэвлэхэд ойлгомжтой цагаан болгоё гэж санал гаргаж байсан. Цагаан болгож, том болгоогүй байна яамныхан. Цагаан болгоод хэвлэхэд харагдахгүй байгаа гэдэг асуудлуудыг түрүүний дэд хорооны хуралдаан дээр яригдсан байгаа шүү дээ.

Д.Цэнгүүнжав: Графикаар харуулбал хамгийн их зарцуулсан гадаадын зээл тусламжаар 50 тэрбум, 2 дугаарт нь улсын төсөв. Тэгээд өөрийн хөрөнгө гээд ийм дараалалтай харагдаж байна.

2022-2025 онд хэрэгжүүлсэн мэдээлэл технологийн чиглэлийн төсөл, арга хэмжээний мэдээллийг тойм байдлаар харуулбал нийтдээ бол 2022-2025 онд бол

81 тэрбум байгаа. Үүнээс яам бол 42 хувь, нийт зарцуулж байгаа зарцуулалтын 42 хувь маань нийт дүнгээсээ яам дээр 42 хувь байгаа. Тэр 42-ыг 100 хувь гэж үзээд задлах юм бол Үндэсний Дата төв дээр 51 хувийг нь зарцуулсан байна. И-Монгол академи дээр бол 2,2 хувь, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар дээр бол 1 хувь, Мэдээлэл холбооны сүлжээ компани дээр 2 хувь, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв дээр 1 хувь, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба дээр бол 0,8 хувь гэж гаргаж байна.

Цахим хөгжил, харилцаа, холбооны яамыг харвал нийт 34 тэрбумаас 42 хувь байгаа. Яг саяын ярьсанчлан. Энэ 42 хувиас 100 хувь гээд үзэх юм бол ерөөсөө хамгийн их нь бол харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл дээр 67 хувь нь дангаараа ганц төсөл эзэлж байгаа.

Салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд гээд 20 хувь. Цахим засаглал ба дижитал шилжилт 10 буюу ерөөсөө нийт 34 тэрбумын 97 хувь нь бол бол 3 төсөл энийг эзэлж байгаа. Ингэж харагдаж байгаа. Дараагийнх дээр нь томоохон төслүүдийг Үндэсний Дата төв дээр 51 хувь байгааг задлаад үзэх юм бол Цахим Монгол платформ техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх дээр 7 хувь, Үндэсний дата төв төрийн клауд дэд бүтцийн сервер тоног төхөөрөмж нийлүүлэх бол 10 хувь, Дата төвийн нэгдмэл дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх 6 хувь, интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийг шинэчлэх 5 хувь, Үндэсний дата төв болон нөөц төвийн хүчин чадлыг өргөтгөх нь 51 хувь буюу 41 тэрбумын маань 79 буюу 80 хувь нь эдгээр 5 төсөл, хөтөлбөр байна. Ерөнхийдөө дандаа тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт гэсэн үг.

Энэ жил энэ улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багц дээр бол Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюуны их өгөгдлийн суурь дэд бүтцийг бий болгох гээд 6 багц үйл ажиллагаа байгаа. Нийтдээ 16 тэрбум. Үүнээс 5 төсөл маань амжилттай хэрэгжсэн байгаа.

Гадаадын зээл тусламж бол цахим яам дээр 2 төсөл байна.

1 дүгээрт нь “Ухаалаг засаг 2” төсөл 40,7 сая ам.доллар,

2 дугаарт сая гарсан Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл буюу 22,1 сая доллар БНХАУ-ын ийм 2 төсөл байж байгаа.

Ухаалаг засаг бол өмнөх дэд хороонд танилцуулга хийсэн. Тэгэхдээ нийт ерөнхий дүнг танилцуулах юм бол 41,7 сая. Монгол улсын Засгийн газрын санхүүжилт буюу 1 сая долларын НӨАТ-ын хөнгөлөлтийг оруулж тооцоод, нийт төслийн тоо бол 57. Энэ бол нөгөө 70,4 буюу анх Байнгын хороонд албан бичгээр ирүүлсэн хувиар байна гэсэн үг. Нийт хэрэгжилт, төслийн хэрэгжилт. Зарцуулалт бол 7,8 сая доллар.

Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл гээд энэ бол БНХАУ-ын Экс-Им банкнаас 95 хувь, мэдээлэл холбооны сүлжээ компаниас 5 хувийг нь санхүүжүүлж байгаа ийм төсөл байгаа. Нийт ашиглалт бол 11,4 сая доллар буюу төслийн хэрэгжилт 52 хувьтай явж байгаа.

Энэ бол Сангийн яамнаас 2025 оны 4 сарын 17-ны өдрийн албан бичгээр авсан нийт хэрэгжүүлж байгаа 2015-2025 оны хооронд улсын төсвийн болон

гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн программ хангамж, мэдээллийн системтэй холбоотой төсөл, арга хэмжээний мэдээлэл байгаа.

Улсын төсвөөр 24 төсөл 104 тэрбум, гадаад зээл, тусламжаар 10 төсөл 226,7 сая ам.доллар гэж харагдаж байгаа. Эндээс харах юм бол цахим яам дээр Дэлхийн банкны болон одоо явж байгаа Хятадын зээл байгаа. Бусад нь бол Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрүүл мэндийн яам гэх мэтчилнээр бусад төрийн байгууллагууд дээр байгаа ийм төсөл хөтөлбөрүүд байгаа.

Дэд хорооноос ирсэн бичгийн хүрээнд нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт гэж 28 дугаар зүйл байгаа.

28.1.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийг Засгийн газар батална.

28.2.Мэдээлэл хариуцагчийн энэ хуулийн 28.1-д заасан ерөнхий төлөвлөлтөд нийцүүлэн байгууллагын нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийг гарган хэрэгжүүлнэ.

28.3.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмыг Засгийн газар батална гэж заасан. Гэвч хэрэгжилт байхгүй байна гэдэг дээр бол мэдээлэл авъя гэж ирүүлсэн. Энэ дээр бол 2026 оны 3 сарын 1-нд тендер шалгаруулалтыг зарлаад, одоогоор гэрээ байгуулаад, ерөнхий төлөвлөлтийг боловсруулах, журмын төслийг боловсруулах компани шалгарчихсан явж байгаа. 2026 оны 1 сард Засгийн газарт танилцуулаад, тэмдэглэлээр үүрэг авсан. 2026 оны 3 дугаар улиралд ерөнхий төлөвлөлт болон журмыг оруулж батлуулах гэдэг энэ хүрээндээ 3 дугаар улиралд танилцуулж оруулахаар явж байгаа.

Нийтийн мэдээллийн систем байгуулах. Нийтийн мэдээллийн систем байгуулахдаа дүгнэлт, зөвлөмж авна гэж 29.1-д мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө Цахим хөгжил, харилцаа, холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулахаар заасан. Яамны зүгээс системгүй байна гээд дүгнэлт зөвлөмжийн системийг ашиглалтад оруулаад, нийтдээ одоогийн байдлаар 48, сүүлд 1 нэмэгдсэн. 49 дээр нь зөвлөмж өгөөд байна. Оноор нь гаргавал 2022 онд 3, 2023 онд 15, 2024 онд 9, 2025 онд 9, 2026 онд 12 үүсгээд явж байна.

Мөн өнгөрсөн жил бол Үндэсний аудитын газраас зөвлөмж өгсөн. Сангийн яам болоод Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 1 дүгээрт нь цахим систем боловсруулах ажлын өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоох аргачлал боловсруул. Тэгээгүйгээс болж төсөл хөтөлбөрүүдийн үр дүн харилцан адилгүй гэх мэт зөндөө асуудлууд байгаа учраас 1 дүгээрт ийм үүрэг өгсөн.

2 дугаарт төрийн байгууллагад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм стандартыг салбарын онцлогтой уялдуулан боловсруулах гэдэг бас үүрэг өгсөн.

Үүний хүрээнд энэ 2 ажил дээр бид нар яг энэ аргачлалын төслийг боловсруулаад, Сангийн яамтай хамтраад ер нь батлуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Дүгнэлт зөвлөмж авсан системүүдийн жагсаалт бол дараагийн хуудсанд байж байна. Нийт 48 систем байгаа.

Манай яам салбарын хэмжээнд бол сая гарсанчлан хууль болон заалтууд хангалттай байгаа. Үүний хэрэгжилт хангалтгүй байна гэдэг үүднээс 2025 оны 11 дүгээр сард Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар Цахим яам хамтраад цахимжсан гэж байгаа боловч хамгийн их өргөдөл гомдол ирж байгаа 5 байгууллага дээр ажилласан. Үүний хүрээнд гэхээр асуудлууд нь юу вэ гэхээр цахимжсан гэж байгаа мөртөө дахиж цаас шаардаж байна гэх мэтчилнээр асуудлууд гарсан. Үүний хүрээнд Ерөнхий сайдын 02 дугаартай албан даалгаврыг бол гаргасан. Энэ дээр жишээ болгоод дундаас нь яахад бол дүгнэлт, зөвлөмж аваагүй бол тендер буюу худалдан авах ажиллагааны системээр зарлахгүй байхыг үүрэг болгосон. Үүнтэй холбоотойгоор дүгнэлт, зөвлөмж бол маш сайн ирж байгаа. Яагаад гэхээр Төрийн худалдан авах ажиллагааны газар маань өөрөө энэ албан даалгаврын хүрээнд дүгнэлт, зөвлөмж аваагүй бол зарлахгүй байгаа учраас зарлах шаардлагатай учраас Цахим яамнаас дүгнэлт, зөвлөмж авахаар сүүлийн үед маш сайн ирж байгаа.

Ерөнхий сайдын 02 дугаартай албан даалгаврын хүрээнд Цахим яамны хариуцсан ажлууд дээр тайлбар, мэдээлэл өгсөн байгаа. Жишээлбэл саяын хэлсэнчлэн ерөнхий төлөвлөлт болон журмыг нь батлах гээд үүнийг үүрэг болгосон. Энэ хүрээнд бид бүхэн нь шалгаруулаад явж байгаа. Тэгээд бид нар уулзаад, 2 талын уулзалтууд хийгээд төслийн саналаа өгөөд явж байгаа гэсэн үг.

Танилцуулга дууссан.

Ч.Анар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Танилцуулж байгаа мэдээлэл дээр дутуу л байгаад байх юм. Жишээ нь энэ нийслэлийн өмчөөр худалдан авалт хийсэн Хотула, тэр нөгөө замын хөдөлгөөний хяналтын системүүд алга байна. Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл дээр авсан худалдан авалтууд алга байна. Энэ Сангийн яамнаас нэгтгэгдэж ирээгүй байгаа юм уу. Танай дээр яг энэ бүтэн мэдээлэл байхгүй л байна даа. Тэрийгээ бас Сангийн яам, аудит 2 дүгнэлт танилцуулах шаардлагатай гэж бодож байна. Золжаргал гишүүнээр тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Эхлээд Сангийн яамнаас асуучихъя. Ингээд тайлантай танилцахаар ерөнхий нийт төсвийн болон төслүүдийн гүйцэтгэл 60 хувьтай гарсан байна лээ. Өөрөөр хэлбэл тухайн өнгөрсөн хугацааны төсвүүдэд тавьсан мөнгөний ерөнхий гүйцэтгэл нь өөрөө 60 хувьтай, маш бага гүйцэтгэлтэй байгаад байхгүй юу. Тэгсэн мөртөө цахим шилжилт нь болохоор уг нь тэргүүн зэргийн ач холбогдолтой ажлууд байгаад байдаг. Үүний шалтгаан нь юу байдаг юм бэ гээд 1 дүгээр асуулт байгаа юм.

2 дугаарт болохоор ерөнхийдөө төр болон хувийн секторынхон бол маш олон мэдээллийг давхар хэлбэрээр дата цуглуулаад байна гэж би бол харж байгаа. Ялангуяа бид нар и-баримт гээд том дата систем байдаг. Энэ и-баримт системийн мэдээлэл бол мэдээж и-баримтаар улсын юунд, төрийн дата хадгалагдаж байгаа. Гэтэл тэрийг чинь бас нөгөө дэлгүүр ажиллуулж байгаа хувийн сектор ч хадгалж байна. Тэр системийг ажиллуулж байгаа хувийн сектор бас хадгалаад, давхар хадгалаад байна уу. Дээрээс нь тэнд бас банкны гүйлгээ явагдаж байгаа. Банкны систем бас хадгалаад байна. Энэ талын дата давхардал ер нь хэр түвшинд байдаг юм бэ. Энэ талаар ямар бодлого барьж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Санхүүгийн мэдээллийн технологийн төв дээр бол нийтдээ 31 систем ашигладаг тухай тайланд дурдагдсан байсан. Тэгэхээр энэ 31 системийг ер нь ингээд бүлэглэж харвал хэдэн бүлэгт хуваагдах юм бэ. Ерөнхийдөө ойролцоо ажил хийгдэж байгаа системийг 1 систем гээд тоолоод байна уу. Эсвэл бүлэглэж тоолоод байна уу гэдэг ийм асуулт байгаад байгаа юм.

Дараа нь Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр энэ худалдан авах ажиллагаа дээр бол ерөнхийдөө хиймэл оюун ухаан сүүлийн үед ашиглаж байгаа гэж яриад байгаа. Тэгэхээр энэ дээр ер нь хиймэл оюун ухааныг бодитоор ажиллуулаад, дээрээс нь болохоор энэ төрийн байгууллагууд байгаа мэдээллүүдээ цуглуулаад, зарим тендерт оролцож байгаа компаниудын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн чанартай холбоотой санал дутагдал яам бүр дээр бараг байдаг юм шиг байгаа юм. Тэгтэл Худалдан авах ажиллагааны газар дээр орж байгаа компанийн мэдээллийг тэгж шалгаж байгаа зүйлс ер нь байна уу, үгүй юу гээд ийм асуудал.

Энэ Үндэсний аудитын газрын тайланг уншихаар бол бас нэлээн анхаарах асуудал гарч ирж байгаа. Ялангуяа Ерөнхий аудиторын тайлан дээр бол тодорхой яам болгон дээр хийгдэж байгаа системд зарцуулсан мөнгө, зарцуулсан хугацаа, өгсөн захиалга, гүйцэтгэлийн хувь, тэгээд яг нөгөө гүйцэтгэлийн хувьтайгаа адилхан нөгөө хэрэгжилт нь яг тэр хувьдаа байна уу, үгүй юу гэдэг нь тодорхой биш байна гэдэг ийм асуудлыг тайлан дээр тавьсан байна лээ.

Тийм учраас энэ асуудлыг ер нь цаашдаа яаж тодорхой болгох юм бэ гэдэг асуудал бол маш чухал болж ирж байна гэж би хараад байгаа. Тийм учраас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас асуух гээд байгаа зүйл юу гэхээр энэ цахим системүүдийг боловсруулахад ТЭЗҮ-ийг нь боловсруулах ажлын өртөг тооцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж хүлээн авахад баримтлах шалгуур гэдэг бодлогыг гаргах ёстой юм байна лээ. Тэр зарчим нь юу байх юм. Өртгийг нь тодорхойлох нь яах юм. Жишиг үнэ тогтоохтой холбоотой зохицуулалт хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлтийг Үндэсний Аудитын газраас хийсэн байсан. Тэгэхээр энэ асуудал дээр ямар ажлууд хийгдсэн бэ гэдэг ийм асуудал. Зарим .../минут дуусав/

Ч.Анар: Индрийн микрофон. Сангийн яам, Цахим яам аль хариулах вэ. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

Д.Цэнгүүнжав: Цэнгүнжав. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч. Жишиг дээр бол сая Үндэсний аудитаас зөвлөмж өгсөн.

1 дүгээрт нь цахим систем боловсруулах ажлын өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоох аргачлал боловсруулах;

2 дугаарт нь төрийн байгууллагад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм стандартыг салбарын онцлогт уялдуулан боловсруулах гээд. Энэ дээр бол 2 компани шалгараад, хоёулаа төслөө боловсруулчихсан. Сангийн яамтай хамт анхны уулзалт, 2, 3 ч удаа ингээд уулзалтуудаа зохион байгуулаад, саналаа хэлээд төслийг гаргасан байгаа. Одоо бид нар ярилцаж байгаад бусад холбогдох газруудаас санал аваад, энэ норм, стандарт, аргачлалуудыг батлуулах арга хэмжээг авахаар явж байгаа.

Мөн бид бүхэн дүгнэлт зөвлөмж авахдаа Сангийн яамтай бас ярилцсан. Одоо яаж яваад байна вэ гэхээрээ ерөөсөө төсөвт тусгагдчихсан яг зарлах гээд зарлахын наана л авахгүй бол болохгүй байна гээд тэгж авч явж байгаа. Тэгэхээр бид нар юу гэдэг юм давхардсан дээр бол давхардаж байна гэдэг байдлаар ямар ч байсан дүгнэлт, зөвлөмж ирж байна. Ер нь цаашдаа бид бүхэн энийг магадгүй 2 шаттай болгоод, анх төсөвт саналаа өгөхдөө ийм төсөв энэ нь өөрөө ийм юм хэмнэх юм гэж ингэж тусахгүй зөвхөн хэзээ хойно нь туссаны дараа зөвхөн юу гэдэг юм ёс төдий иймэрхүү байдлаар хязгаарлалт хийж байгаа нь зохимжгүй байна гэдэг байдлаар Сангийн яамтай ярилцаад, төсвийн санал авахдаа бас тэдний дээр байдаг журам байгаа гэсэн. Энэ журам дээр бас энийг тусгаад, анх төсвийн санал өгөхдөө энэ нь өөрөө давхцаж байгаа эсэхийг нь ядаж эхний байдлаар том агуулгаар нь хараад, дараа нь ажлын даалгаврын хэмжээнд дахиж хардаг байхаар байх нь зөв юм байна гэдэг байдлаар ярилцаад явж байгаа.

Ч.Анар: Сангийн яамны төрийн микрофон.

Б.Ганзориг: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг. Сая бас дэд ажлын хэсгийн дарга Анар гишүүн хэлсэн. Ер нь бол бусад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дээд шүүх, СЗХ зэрэг ер нь бусад бүх төрийн байгууллагуудад ерөнхийдөө мэдээллийн технологийн чиглэлээр төслүүд хэрэгжээд явж байна. Тухайлбал, Улсын Их Хурлын дарга дээр байгаа, Хууль зүй, дотоод хэргийн яам дээр, АТГ зэрэг газруудад ингээд ерөнхийдөө 2022-2025 оны хооронд нийтдээ 63,8 тэрбум төгрөгийн ажлууд хийгдсэнээс одоо яг батлагдсан төсвөөс ашиглагдаагүй үлдэгдэл нь бол 36,7 тэрбум төгрөг байна. Тэгэхээр хэрэгжилт бол таны хэлснээр ерөнхийдөө бас 60 орчим хувьтай явж байна. Сангийн яамнаас бол төсвийн хөрөнгө оруулалттай эдгээр төслүүдийг батлагдсаны дараа мэдээж та бүхэн мэдэж байгаа. Худалдан авах ажиллагааг бол янз бүр зохион байгуулж байгаа. Заримыг нь бол Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр, заримыг нь яамд өөрсдөө зохион байгуулаад явж байгаа. Тэгэхээр энэ хэрэгжилттэй холбоотой асуудал дээр яг захиалагч яамдын өөрсдийнх нь гол хариуцлага байгаа. Тэгэхээр жишээлбэл Улсын дээд шүүх дээр сая ажлын хэсгийн дарга Анар гишүүний асуусан систем бол нийтдээ 2,5 тэрбум төгрөгөөр батлагдсанаас өнгөрсөн онд уг нь ашиглаад дуусах ёстой байсан. Гэхдээ үнэ бол 1,9 тэрбум төгрөг жишээ нь ашиглагдаагүй үлдсэн. Тэгэхээр тэр системийн хөгжүүлэлтийн асуудлууд дээр захиалагч яамд нь өөрсдөө бас худалдан авах ажиллагаагаа зохион байгуулсан бол тэр дээрээ хариуцлага хүлээгээд явах ёстой. Тайлагнаад явж байгаа.

Мэдээж Үндэсний аудитын газраас өнгөрсөн оны төсвийн гүйцэтгэл, мөн Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан Их Хурал руу 6 сарын 10-ны дотор хүргэгдэнэ. Тэгэхээр энэ дээр бас хэрэгжилтийг дэлгэрэнгүй яриад, яг төсөл, арга хэмжээ болгоноор нь яриад явах боломж нь бүрдэж байгаа гэж ойлгож байгаа.

Тэр манай харьяа байгууллага дээр байгаа 31 системийн талаар би бас танд дэлгэрэнгүй мэдээллийг эргэж хариуцаж байгаа газраас нь авч өгье. Яг одоогоор бас бид нар дээр бэлэн мэдээлэл байхгүй байна.

Ч.Анар: Худалдан авах ажиллагааны газар. Индрийн микрофон.

Ц.Батзул: Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Хиймэл оюун ухааны талаар Дэлхийн банкны “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд тендер шалгаруулалт зарлаад, гүйцэтгэгчийг

сонгон шалгаруулчихсан. Одоо гэрээний шатдаа явж байгаа. Энэ гүйцэтгэгчийн хийх ажлын даалгаварт нь бол хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх ажлууд орсон байгаа. Тэгээд Эрдэнэт дээр байгаа жишээг бас авч судлах даалгавар бол Засгийн газраас өгсөн. Энэ хүрээндээ бас хэрхэн энийг нь нэвтрүүлж болох талаар судалгааг нь хамтраад нөгөө гүйцэтгэгч байгууллагатай хийхээр байгаа. Яг одоо манай Монголд байгаа эрх зүйн орчны хүрээнд бол хиймэл оюун шууд тендерийн хариу гаргах ер нь бол боломжгүй. Заавал энэ дээр хууль, эрх зүйн орчин хэрэг болно.

Харин хиймэл оюуныг яаж ашиглах вэ гэхээр 2 түвшнээр бид нар төлөвлөгөө боловсруулж ажиллаж байгаа.

1 дүгээрт хиймэл оюунаар бид нар оролцогч тендерээ илгээхээсээ өмнө захиалагчаас шаардаад байгаа материалаа бүрэн бүрдүүлсэн юм уу гэдгээ шалгах боломжтой байхаар ажлын даалгаварт орсон байгаа.

2-т нь Үнэлгээний хороо тендер нээсний дараа ирүүлсэн оролцогчийн материал нь бүрэн эсэх асуудал дээр бас дүгнэлт өгөх ийм хэлбэрээр ашиглана гэсэн эхний ээлжид ажлын даалгавар боловсруулчихсан, одоо гэрээний шатандаа явж байна.

Мөн манай төрийн худалдан авах ажиллагааны систем маань анх 2014 онд 1,5 тэрбум төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалттайгаар хөгжүүлээд, 2017 оноос ашиглаж эхэлсэн байгаа. Өнгөрсөн 9 жилийн хугацаанд техник технологийн өөрчлөлтийг бас төдийлөн авч чадаагүйгээс болоод одоо бол нэлээдгүй хоцрогдсон, бүх кодыг шинэчлэх шаардлага бол үүссэн байгаа.

2023 онд Их Хурлаас тендерийн хуулийг шинэчлэн баталсан. Энэ хуулиар бол ер нь төрд байгаа мэдээллээ оролцогчоосоо нэхэхээ боль гэдэг ийм зохицуулалтууд орсны хүрээнд тендерийн системээ аль болох төрийн мэдээллийн сангуудтай холбогдож байгаа.

Соронзонболд гишүүний түрүүний хэлдэг нөгөө гэрээгээ олигтой гүйцэтгэдэггүй компанитай холбоотой мэдээллийг хэрхэн хангаж байгаа вэ гэхээр Сангийн яамны хөрөнгө оруулалтын системтэй холбож байгаа. Одоо бүх улсын болон орон нутгийн төсвөөр санхүүжих гэж байгаа төслийн маань хэрэгжилт нь түүнд ороод явах юм бол эндээсээ мэдээлэл аваад,, муу гүйцэтгэлтэй байх юм бол үнэлгээнд нь харгалзаад явах энэ холболтыг нь бол 6, 7 сардаа хийгээд дуусна. Тэгэхээр цаашдаа тендерт оролцсон компаниуд маань өмнө нь хэрэгжүүлж байгаа ажил нь яг хэрэгжиж байгаа юм уу гэдэг дээр нь бас үнэлэлт, дүгнэлт хийх боломж нь бас гараад явна.

2 дугаарт тендерийн системийг бол бусад мэдээллийн сангуудтай тухай бүр нь холбоод явж байгаа. Одоо яг 20 гаруй API холболтоор нь бол мэдээллийг нь шууд эх өгөгдлийнх нь сангаас нь авч байгаа. Бид нарт тулгарч байгаа ганц асуудал юу вэ гэхээр гадаадын этгээдийн хувьд яг ийм үнэлгээ та нар хийж чаддаг уу гэдэг асуултыг бол хувийн хэвшлээс өгдөг. Монгол Улсын хуулийн этгээдийгээ бол та нар бүх түвшинд нь нарийн шалгадаг юм байж .../минут дуусав/

Ч.Анар: Индрийн микрофон дахиад 1 минут.

Ц.Батзул: Хувийн хэвшлийн хувьд бол та бүхэнд Монголын хуулийн этгээдийг бол янзын шалгадаг юм байна. Харин гадаадын этгээдийг нь та нар хэрхэн шалгадаг юм бэ гэдэг дээр бол нэлээдгүй асуудал тавьж байгаа. Тэгэхээр энийг ер нь цаашдаа бас дээд түвшиндээ хэрхэн үзэх юм, яах ийх юм гэдгийг нь бас тодорхой хэмжээнд шийдвэрлээд явахгүй бол яг шударга өрсөлдөх боломжтой байна уу гэдгийг нь та нар яг үзэж чадаж байгаа юм уу гэдэг дээр бас нэлээдгүй маргаантай байгаа.

Дараагийн системээ хөгжүүлэхдээ бас энийгээ давхар анхаараад явъя гэдэг төлөвлөгөөтэй байгаа. Тухайлбал, Монгол улсын хуулийн этгээд тендерт ороход татварын өрийг яг өнөөдрийн байдлаар рийл таймаар харж болдог. Гэтэл Солонгос, Турк, Америк эсвэл Хятадын компаниуд маань яг өртэй юм уу гэдгийг ижил түвшинд үнэлж болж байна уу гэдэг асуудал бас байнга тавьдаг байгаа. Баярлалаа.

Ч.Анар: Сангийн яам нэмж тодруулъя. Индрийн микрофон. Соронзонболд гишүүний асуултад нэмж тодруулъя.

Б.Ганзориг: Нөгөө хариуцсан газраас мэдээлэл ирсэн учраас би бас Соронзонболд гишүүний асуултад нэмээд хариулъя. Манай харьяа байгаа Мэдээлэл технологийн төв дээр нийтдээ 31 систем байна. Энэ 31 системийг ерөнхийдөө 3 үндсэн гол бүлэгт хувааж авч үзэж байгаа юм байна. Төсвийн орлогын чиглэлээр ашиглаж байгаа нийтдээ 8 систем, төсвийн зарлагын чиглэлээр ашиглаж байгаа дол 7 систем, үлдсэн бүх систем нь яг төсвийн үйл ажиллагааны хяналтын системүүд байгаа юм байна. Одоо тухайлбал төсвийн орлогын систем дээр байгаа 8 системийг тухайлбал таны түрүүний хэлдэг и-баримт, мөн цахим татварын систем, и-такс гэх мэтчилэн нийтдээ орлогын чиглэлээр бол 8, зарлагын чиглэлээр 7 систем. Энэ дээр бол нөгөө халамжийн системүүд байна. Мөн төрийн албаны цалингийн нэгдсэн системүүд байна. Валютын гүйлгээний нэгдсэн систем, шилэн данс гэх мэтчилэн яг төсвийн зарлага тал дээрээ бас ийм 7 систем. Үлдсэн хяналтын систем ../минут дуусав/

Ч.Анар: 1 минут нэмж өгье.

Б.Ганзориг: Хяналтын системүүд дээр тухайлбал зөвшөөрлийн систем, мөн ухаалаг гарц гээд вакцинжуулалт гэх мэтчилэн ийм нийтдээ 31 системийг бол яг энэ 3 төрлөөр бүлэглээд ашиглаад явж байгаа юм байна. Түрүүний бас ярьсан нөгөө и-баримтын систем дата тэр бол ерөөсөө Сангийн яаман дээр ямар нэгэн байдлаар энэ системүүд и-баримтын мэдээлэл цуглуулдаггүй. Яагаад гэхээр энэ хувийн хэвшлийн дата учраас энэ мэдээлэл зөвхөн хувийн хэвшил дээр хадгалагдаад явдаг юм байна.

Ч.Анар: Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас тодруулъя гэж бодож байна. Тайланг уншихаар аймгууд дээр, нийслэл дээр, сум дээр захиалга өгч байгаа программ хангамжийн шаардлагууд нь их ойролцоо. Тэгсэн мөртөө улсын хэмжээнд нэлээн их мөнгөө зарцуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүний нэгдсэн бодлого, яг энэ чиглэлийн программ хангамжийн хөгжүүлэлт чинь энэ систем дээр хийгдчихсэн. Тэр нь төрийн байгууллагуудын хувьд ингээд бүгдэд нь адилхан хэрэглэх боломжтой интеграцлагдсан байдаг гэдэг энэ дүгнэлтүүдийг хэр өгдөг юм бэ. Яагаад гэхээр тайланг уншихаар суманд хүртэл хийгдэж байгаа программ хангамжийн шаардлага бүх зүйл нь маш адилхан.

Нийслэл дээр хийгдэж байгаа нь адилхан. Төрийн байгууллагууд дээр хийгдэж байгаа, яамд дээр хийгдэж байгаа нь адилхан иймэрхүү шаардлагууд бас нэлээн харагдсан. Энэ тал дээр ямар бодлого барьж, яг хэзээ одоо та хэдийн саяын яриад байгаа шаардлага чинь дуусах гээд байгаа юм. Тэгээд энэ нэгдсэн бодлогоор хэзээ хангаж эхлэх юм бэ гэдэг асуулт.

Ч.Анар: Индрийн микрофон.

Д.Цэнгүүнжав: Асуултад хариулъя. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Цэнгүүнжав. Дүгнэлт зөвлөмж бол системийн бүртгэл хийгдсэнээр бид нар хаана ямар систем байгаа юм бэ. Хаана яаж давхардаж байна гэдгийг гаргах боломжтой болох юм. Тэгэхээр өмнө нь бол хэрэгжилт хангалтгүй байсан, сүүлийн үед маш сайн хэрэгжиж байгаа. Сүүлийн үед ялангуяа нийслэлээс жишээлбэл тэр тогтоол гарсны дараа худалдан авах дээр зарлахгүй гэсэнтэй холбоотойгоор нийслэлээс ирж эхэлсэн. Өмнө нь бол бид нар нийслэл дээр бүртгэсэн юм байхгүй байсан. Аймаг, сумын Засаг дарга нараас бол яг энэ бүртгэл хийгдэхгүй байгаад байгаа. Хэрэгжилт хангалтгүй байгаа гэсэн үг. Уг нь албан даалгаврын биелэлтийг бид нар ингээд нэхээд авна. Бид нар бол яг энэ бүртгэл хийж чадсанаараа давхардаж байгаа, давхардахгүй байгааг ангилж чадаж байгаа.

Саяхан нийслэл дээр ирсэн төсвийн орлогын систем хийлгэх ажил ирсэн. Энэ дээр яасан гэхээр бид нар Сангийн яамнаас тодруулга мэдээлэл аваад ийм юм байдаг гэдэг тайлбар аваад, энэ давхардаж байна гэдэг дүгнэлт өгсөн учраас, тэднийх больсон гэх мэтчилнээр бид бүхэн яг энэ бүртгэл маань сайн яваад .../минут дуусав/

Ч.Анар: Ренчиндоржийн Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Би ганц 2 зүйл асуух гэсэн юм. Цахим хөгжлийн яам чинь яг яадаг яам юм бэ. Одоо энэ та хэдийн хийж байгаа энэ танилцуулга дээр салбарын хувьд гэж яриад байх юм. Нийт Монгол Улсын нийт хэмжээнд нь авч үздэг юм уу. Эсвэл зөвхөн өөрийнхөө салбарыг яриад яваад байдаг юм уу. Тэгээд энэ ирүүлж байгаа материалыг харлаа. Сангийн яамнаас авсан гэж байх шиг байна. Тэгээд энэ дотор чинь зөвхөн мэдээллийн технологийн чиглэлээр зарлагдсан тендер шалгаруулалт гээд тэгсэн энэ төрийн худалдан авахтай ч бас хамаатай юм шиг байх юм. Тэгсэн дотор нь энэ чинь юу гэсэн үг юм бэ. Хөвсгөл аймгийн сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам, сүлжээ, барилга байгууламж барих ажил гээд дотор нь бөөн юм ороод ирчихсэн. Энийгээ та нар ялгаж чаддаггүй юм уу, чаддаг юм уу. Та нар чинь уг нь Цахим хөгжлийн яам биз дээ. Тэгээд энийгээ ялгачих арга тал байдаггүй юм уу.

Яг хэчнээн төгрөгийн ажил яг цахим дээрээ орчхоод байгаа юм бэ. Энэ чинь барилгын зураг төсөл нь холилчихсон ийм юм өгчхөөд өөрсдөө ялгаад хараад наадхаа дүгнэ гэж байгаа юм шиг ийм юм яваад байх юм. Энийг яах ёстой юм. Тэгээд та хэд чинь Сангийн яамнаас мэдээлэл авч ажиллах ёстой юм уу. Өөрсдөө эсвэл салбарын яамд, ерөнхийлөн гүйцэтгэгч нартайгаа холбогдоод, ямар ажил тухайн жилдээ хийгдэх ёстой юм, хийгдэх гээд байгаа юм гэдгээ төлөвлөөд явдаггүй юм уу. Би бүр энийг гайхаад, асуумаар санагдаад байна.

Ч.Анар: Индрийн микрофон.

Б.Мягмарнаран: Сайн байна уу. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Мягмарнаран. Яг таны хэлж байгаа асуудал үнэн. Бид бүхэн бол улсын хэмжээний бодлого мэдээж гаргаж ажиллаж байгаа. Тэгээд хэдийгээр хууль маань 2021 онд батлуулаад, 2022 оноос мөрдөж эхэлсэн ч гэсэн хуулийн хэрэгжилт хангагддаг байсан. Өөрөөр хэлбэл сая өнгөрсөн хугацаанд түрүүн статистик мэдээллээр үзүүлсэн нийт 4 жилийн хугацаанд 48 нь л бид нар санал, дүгнэлт гаргасан. Тэгээд үүнтэй холбоотой бид нар энэ онд Засгийн газарт танилцуулаад, үүнтэй холбоотой Ерөнхий сайдын албан даалгавар гаргаад, хуулийн хэрэгжилтийг хангая. Бусад байгууллагууд маань яг үүнтэй холбоотой хэрэгжилтийг хангах саналуудаа заавал Цахим яамнаас авч байж тендерийг нь нэе гэдэг тийм шаардлага гарсан. Яг энэ заалт нь болохоороо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дээр заасан байдаг. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах асуудлаар цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлтийг авч байж явна гээд. Тэгээд одоо Ерөнхий сайдын албан даалгавартай холбоотойгоор одоо энэ байгууллагууд маань ирээд байгаа юм. Өмнө нь болохоор бид нар мэдээлэл цуглуулах гээд ирдэггүй, байгууллагуудаас мэдээлэл цуглуулж чаддаггүй байсан асуудал байгаа. Тийм бас гаргасан. Тэгээд ерөөсөө хэрэгжилт хангалтгүй. Бид нар энэ талаар холбогдох байгууллагуудад бол маш олон бичгийг явуулж танилцуулж байсан.

Ч.Анар: Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Яах вэ, ер нь яамны хувьд гэж ярих юм уу яам чинь хэдэн хүнтэй юм. Танайх боловсон хүчин бол гайгүй юу. 89 гэдэг чинь бас гайгүй л бүтэц байгаад байдаг. Тэгээд ажлаа хийж чадахгүй байгаа бол яагаад хийж чадахгүй байгаа юм гэдгээ бас ярьчихмаар байгаа юм. Тэгэхгүй бол яамд нь ингээд хэрэгжүүлэхгүй байсан гээд 2024 оны тогтоолыг хэрэгжүүлээгүй. 2026 онд дахиад албан даалгавар гаргачихсан яваад байдаг. Одоо бүхэл бүтэн 5 жил боллоо. Тэгээд Цахим хөгжлийн яам маань ийм байж болохгүй байгаад байна.

Бас яг энэ мэдээлэлтэй холбоотой гэх юм уу, холбоогүй гэх юм уу танай яаман дээр байгаа бас 1 сонгон шалгаруулалтын асуудал байсан шүү дээ. Тэр эртээдийн ярьдаг нөгөө 7 тэрбумын асуудал. 1500 хүний сургалт хийнэ. Тэд нар нь өөрсдөө цахим ажилтай болоод, тэгээд орлого олоод явна гэдэг .../минут дуусав/

Ч.Анар: Батболд гишүүнд 1 минут.

Р.Батболд: Энэ дээр чинь дахиад асуудал үүсчихсэн яваад байх юм. Та нар яаж шалгаруулах гээд байгаа юм. үр дүнг нь яаж тооцох гээд байгаа юм гээд байсан. Уг нь их л аятайхан юм яриад байх шиг байсан чинь тэр фэйсбүүк дээр яваад байна лээ шүү дээ. Бадамцэцэг Лхагва гэсэн хаяг дээрээс. Манайх угаасаа ийм ажил хийгээд байхад яагаад бид нарыг дэмжихгүй, гаднын юм оруулах гээд байгаа юм бэ. Гаднын юм оруулахдаа тэр тендерийнхээ материал дээр ийм юм байдаг юм шүү. Ийм нэг компани байдаг юм шүү гээд манай нэрийг оруулчихсан ч явж байх шиг гээд. Тэгээд энэ дээр та нар ямар бодлого барьдаг юм. Тэгээд үр дүнгээр нь та нар санхүүжилтийг нь өгөх гээд байгаа юм уу. Эсвэл зүгээр өгчхөөд дараа нь ёстой хэрэгжиж болсонгүй гэж ярих гээд байна уу. Энэ дээрээ яг тодорхой хариулаад өгөөч.

Ч.Анар: Индрийн микрофон. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Цэнгүүнжав. Өмнө нь бас яг хэлж байсан.

1 дүгээрт, үр дүнгээр нь бол санхүүжилтийг нь өгнө. Тэгээд орлогоор баталгаажна. Тэгээд цахим орчинд гарч байгаа шиг 1 удаагийн 80 доллар гэсэн юм байхгүй. Энэ маань өөрөө 6 сарын турш гэж байгаа. Тэгэхээр 80-ыг 6-аар үржвэл жишээлбэл 480 доллар болно гэх мэт ташаа мэдүүлээд явж байгаа. Хяналт хэрэгжүүлэх газар дээр бол гомдол өгөөд, тэрнийх нь дагуу бид нар бас мэдээллээ гаргаж өгсөн. Иргэний мэдээлэл бол тэр ижил төстэй нь бол үнэн. Тэр тайлан дээр дурдчихсан зүгээр судалгааны эшлэл байгаа. Foot note дээр. Жишээлбэл Монголд ийм ийм газрууд байна. Тэгэхдээ эд нар ингээд болно. Тэгэхдээ эд нарын маань өөрөө санал болгож байгаа ажил маань бага буюу good starting point гэдэг үг байгаа байхгүй юу. Тэгэхээр эд нарыг оролцуулж болно. Тэгэхдээ энэ бол Дижитал online gig job дээр бол Монголд ийм ийм газрууд байна. Энэ гэхдээ манай төсөл бол олон улсын зах зээл дээр байгаа ажлыг Монгол хүн хийгээд, олон улсын зах зээл дээрээс доллар, юу гэдэг юм цалингаа авах гэдэг ийм зарчимтай. Уг нь яг зөв тайлбарлах юм бол ийм байгаа. Жоохон мэдээллийн зөрүүтэй мэдээлэл өгөөд явж байгаа. Энэ талаар мэдээлэл өгөх гээд иргэнтэй уулзахаар цаг товлосон боловч сүүлд өөрөө цуцлахыг хүссэн байгаа.

Ч.Анар: Батболд гишүүн сүүлийн тодруулга.

Р.Батболд: Яах вэ зүгээр тэр 80 гэдэг нь ч худлаа байх. Яагаад гэвэл бид нар сарын 480 гэж ойлголцсон шүү дээ. Тийм байсан тийм ээ. Олох орлого нь 1 хүний гэж ойлголцсон. Сарын 480 гэж ойлгуулаад байсан биз дээ. Одоо протоколоо та нар эргүүлээд харах юм бол би наадах чинь яах вэ 7 тэрбумаа бид нар 3, 4 сарын дотор олчих юм байна гэж ярьж байсан. Тэрийг санаарай. Хэрвээ сарын 80 бол наадах чинь бүтэлгүй юм байна шүү.

2 дугаарт гэвэл би байнга ярьдаг юм. Наадах чинь ерөнхий гүйцэтгэгч гэдэг нэрийн доор баахан мөнгийг нь аваад явчихдаг, наад доор нь байгаа ажил хийж чадаж байгаа Монгол компани байдаг юм уу, одоо энэ start up-ууд чинь өөрсдөө юу ч үгүй хоцорчхоод байдаг ийм асуудлууд байдаг. Энийг бас битгий ийм цахим юман дээр давтчихаарай гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд та нарын ажил дээр битгий энийг бас давтчихаарай. Барилгын ажил хийхээр зүгээр 10, 20 хувийг нь ерөнхий гүйцэтгэгч нэрээр авчхаад суугаад байдаг. Яг ажил хийж байгаанууд нь мөнгө нь хүрэхгүй баларчхаад байдаг. Гэтэл одоо ийм юман дээр битгий .../минут дуусав/

Ч.Анар: Батболд гишүүн үг хэллээ. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Золжаргал: Ер нь нийтийн мөнгийг юунд зарцуулж байна гэдгийг л анхаарал хандуулаад байгаа шүү дээ. 2025 оны 1 сард юм байна шүү. 1 сарын 14-нд Байнгын хорооноос 29 дүгээр заалтыг хэрэгжүүлж, яамнаас зөвлөмж аваагүй бол битгий төсөв олго гэсэн агуулгатай тогтоолыг Засгийн газарт чиглэл болгож өгсөн. Тэгээд харамсалтай нь жил гарангын дараанаас адилхан агуулгатай даалгавар Ерөнхий сайдаас гарч байж арай гэж хэрэгжиж байгаа юм шиг байна. Тэрнээс өмнө хэд хэдэн удаа асуултууд тавиад байсан. Энэ жил арай сайжирч байгаа, асууж эхэлсэн гэж мэдээлж байсан. Тэгэхээр хууль нь биччихсэн байхад хэрэгжүүлж өгдөггүй.

Би асуулт асууя. 1 дүгээрт нь ойролцоогоор 1 их наяд төгрөг юм байна. Энэ танилцуулга дээр тавьсан мэдээлэл. Төсөв, тэгээд гадаадын зээл тусламж зарцуулжээ. Энэ дотор юу ороогүй байгаа бол нөгөө орон нутгийн засаг захиргааны нэгжүүд, орон нутгийн өмчит компани, төрийн өмчит компанийн худалдан авалтууд байгаа юу, үгүй юу. Хууль хүчний байгууллагынх байгаа юу. Нөгөө нийслэлийн бид

нар тусад нь мэдээлэл сонссон шүү дээ. 235 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас сүүлийн 2 жил 220 тэрбум нь ч билүү их том дүнтэй өссөн байсан. Тэд нар орсон байгаа юм уу.

60 хувь гарангын гүйцэтгэлтэй юм шиг байна. Тэрийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл хэд болох вэ. Одоо хэдэн ширхэг бүтээгдэхүүн хэдэн төгрөгийн өртөгтэй бүтээгдэхүүн хэрэгцээгүй эсвэл ажиллахгүй байгаа вэ гэдэг асуулт байна.

Дараагийнх нь асуулт. Энэ 29.1 дэх заалтыг хэрэгжүүлж байгаа. Нийт 48, энэ жил 12. Энэ жилийнх 12 гэдэг нь хэдэн хувь бэ. Хувиар илэрхийлбэл нийт худалдан авалтынх нь.

Тэгээд цахим системд өртгийн үнэлгээ хийдэг, техник хэрэгслийн норм боловсруулдаг ийм зүйл боловсруулж байгаа гэж байгаа юм. Энэ аргачлалыг хэн боловсруулаад, хэн хянаж хэрэгжүүлэх вэ. Энэ дээр энэ салбарт нь байгаа компаниуд, холбоодыг нь өөрсдийг нь оруулаад, бие биеийгээ өөрөө өөрсдийгөө хянадаг иймэрхүү тогтолцоо байж болох уу, үгүй юу.

Дараа нь төрийн хөрөнгө оруулалттай худалдан авалтуудын нийлбэр дүн, цахим систем болоод мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, хувийн салбарт хийгдэж байгаа нийт цахим мэдээллийн технологийн бүтээгдэхүүнүүдийн хоорондын харьцаа гэж тоо байна уу. Нийт бүтээгдэхүүн гэж 1 тоо гаргах юм бол хэдийг нь төр үйлдвэрлээд, хэдийг нь хувийн хэвшил үйлдвэрлэж байна вэ. Эсвэл төр худалдан аваад хэдийг нь зах зээл өөрөө өөрийгөө хангаад явж байна вэ. Ийм асуудал байна.

Сүүлийнх нь тэр Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн асуудлууд хэр явж байна.

Ч.Анар: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. Индрийн микрофон.

Д.Цэнгүүнжав: Манай яг энэ танилцуулга дээр байгаа эхний хэсэг бол яг манай салбарынх байгаад байгаа. Тэгээд ер нь бол яг энэ дүгнэлт зөвлөмжийн системийн хэрэгжилт хангалтгүй шиг бас энэ төсөл хөтөлбөрийн уялдаа холбоо бол бас тийм байгаад байгаа. Мэдээлэл байхгүй. Уялдаа холбоог яг яаманд одоо юу гэдэг юм албан бичгээр ийм мэдээлэл авъя гэдэг байдлаар ханддаг боловч ирдэггүй. Жишээлбэл Майкрософт үнэ бууруулах болон Монголд байршуулах талаар ажлын хэсэг гарсан. Тэрэнтэй холбоотой мэдээлэл технологийн төсөл хөтөлбөр, худалдан авалтын мэдээллийг Худалдан авах ажиллагааны газраас гээд бичиг явсан боловч хариу ирээгүй ч гэдэг юм уу. Сангийн яамнаас бас шаардсан мэдээллүүд ерөөсөө гарч ирдэггүй. Энэ бодит нөхцөл байдал нь бид нар хэрэгжилтээ хангах гээд байдаг, тэгэхдээ нэгтгэл хийх боломжгүй мэдээлэл ирдэггүй ийм бодитой зүйлүүд бол байгаа.

Аргачлал дээр ингэсэн. Ер нь бол цахим яаман дээр ч гэсэн сая гишүүд хэлж байсан. Хүний нөөцийн ч гэдэг юм уу, маш олон чиглэлээр явахаар 1, 2 хүн ч юм уу бүх бодлогыг тодорхойлох боломжгүй. Тийм учраас бид аль болох яг мэргэжлийн холбоод, мэргэжлийн газруудтай нь бол энийг хамтарч ажиллахаар явж байгаа.

Тэгэхдээ мэргэжлийн нэгдсэн холбоо буюу уг нь яг ийм байх юм бол бид нар юу гэдэг юм том том системүүдийн ажлын даалгаврын асуудал яригддаг, өртгийн асуудал яригддаг. Жишээлбэл мэргэжлийн холбоогоор нь хянуулаад явах

боломжтой, энэ нь өөрөө зөв юм гэж харж байгаа. Тэгэхгүй зөвхөн яаман дээр 2 хүн ч юм уу ингэх нь өөрөө боломжгүй байгаад байгаа учраас энэ тал дээр аргачлал боловсруулах дээр сүүлд яриад байгаа метатай саналаа өгөөч гээд ажлын хэсэг байгуулаад, хамтраад явж байгаа. Нөгөө төсөв, норм өртөг дээр нь бол метаг нь өөрөө яг холбоо нь өөрөө ялчихсан юм байна лээ. Тэгээд тэднийхээр боловсруулагдаад гараад явж байгаа.

Мөн Жайкагаас бол Японы тусламжийн төсөл явж байгаа. Энэ маань өөрөө яг энэ харилцаа холбооны салбарууд дээр энэ мэргэжлийн холбоодынх нь тогтолцоо, эко системийг нь бий болгох дээр хууль, эрх зүйн орчныг бий болгох гээд 1 ажлын хэсэг, бүх оролцогч талыг нээлттэй зарлаад, 2 дахь нь start up компаниудыг бий болгох, 3 дахь нь AI дата систем ч гэдэг юм уу 4, 5 нэмэлт чиглэлээр яг тэр хувийн хэвшлүүд ажлаа мэддэг яг тэр асуудал тулгарч байгаа газрууд нь нэгтгээд саналаа боловсруулаад явахаар ийм н ажлын хэсгүүд байгуулагдаад явж байгаа.

Ч.Анар: Сангийн яам. Индрийн микрофон.

Б.Ганзориг: Сангийн яам Ганзориг. Золжаргал гишүүний асуусан 1 их наядын төсөвт өртөгтэй ажлууд хийгдэж байгаа дээр ямар ямар ажлууд орсон бэ гэдэг дээр бас тодруулж, нэмж хариулт өгье. Бид нар Цахим хөгжлийн яаманд хүргүүлсэн мэдээлэл дээр бол орон нутгийн төсөв, төрийн өмчит компаниуд болон хууль хүчний байгууллагуудын нууцаар явж байгаа төслүүдийн мэдээлэл бол ороогүй. Энд орсон мэдээлэл дээрээс бас танд нэг тодруулга хэлье. Тэгэхдээ энэ нөгөө төсөвт өртөг нь 1 их наяд руу яагаад ингэж том дүнтэй байгаа вэ гэдэг дээр жишээлбэл гадаад зээл, тусламжийн төслүүд дээр Энэтхэгийн санхүүжилтээр хийгдэж байгаа аутсорсингийн төв барих ч юм уу барилгын ажлуудын төсөвт өртгүүд бас орсон байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. Тухайлбал, саяын миний ярьдаг Боловсролын яаман дээр хийгдэж байгаа Энэтхэгийн аутсорсингийн төв барих төслийг бол бид нар энэ мэдээлэл технологийн үйлчилгээний чиглэлээр хийгдэж байгаа төсөл гэж оруулсан байгаа.

Мөн түрүүний ярьсан Ухаалаг засаг төсөл маань бол өмнө нь бараг бүх салбаруудыг хамраад хэрэгжсэн төсөл байгаа. Тэр бол И-Монголиа, тэгээд мөн Үндэсний дата төв гэх зэрэг газруудад хэрэгжсэн. Монгол банк дээр бас хэрэгжсэн төсөл байгаа. Тэр бол төлбөрийн системийн шинэчлэл гээд төслүүд байна. Үүнтэй адилхан бас нөгөө АЕГ-ыг бас шинээр барьсан. АЕГ-ын барилга барьсан бас ийм төсөл байгаа. Тэгээд энэ маань бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц дээр бас том дүнтэй хэрэгжсэн барилгууд байгаа. Тогтвортой амьжиргаа 3 гээд та бас мэдэж байгаа байх. Энэ төсөл маань бол өмнө нь бүх 21 аймгийг хамраад хэрэгжсэн. Тэгээд орон нутгийн хөгжлийн сангийн системийг жишээлбэл боловсруулсан гэх мэтчилэн ийм төслүүд байгаа. Тэгэхээр ямар ч байсан энэ 1 их наяд гэдэг тоонд бол зөвхөн зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал дээр бас орсон сүүлийн 5 жилийн ийм ажлууд байгаа.

Ч.Анар: Индрийн микрофон. Нэр албан тушаалаа хэлээд, Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Ц.Батзул: Төрийн худалдан авах ажиллагааны газар Батзул. Золжаргал гишүүний асуултад хариулъя. Нийтдээ Монгол Улсад бол жилдээ давхардсан тоогоор 20 орчим мянган тендер шалгаруулалт зарлаж байгаа. Нийт төсөвт өртөг нь санхүүжих дүн нь биш нийт төсөвт өртөг нь 30 орчим их наяд төгрөг байгаа. Үүнээс ингээд харах юм бол Цахим яамнаас манай төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс түлхүүр үгээр хайлт хийж хэчнээн тендер

шалгаруулалт зохион байгуулагдсан талаар мэдээлэл гаргаж ирүүлэхийг хүссэн байгаа. Энэ хүрээндээ мэдээллийн систем, программ, цахим систем, сервер гэх зэрэг түлхүүр үгээр хайхад 2025 оны хувьд бол 175 тендер шалгаруулалт, нийт төсөвт өртөг 103 тэрбум төгрөг, 2026 оны хувьд 24 төсөл, арга хэмжээ 11 тэрбум төгрөг, 2024 онд бол 196 төсөл, арга хэмжээ 274 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна гэж тоог хүргүүлсэн байгаа.

Ч.Анар: Золжаргал гишүүн тодруулъя.

Ж.Золжаргал: Энэ нөгөө орон нутгийн төрийн өмчит компани, хууль хүчний байгууллагуудынх нь нууцлалтай болохоор ороогүй гэж байна. Тэгээд энэ нууцлалтай байдаг юм байгаа биз. Ер нь салбарт нь юу болоод байгааг мэдэж байх үүднээс энэ тоонууд ер нь та нарт байдаг юм уу. Яамнаас асууя. Ер нь Монгол Улсын цахимжилт хэдэн төгрөгөөр яваад байна.

2 дугаарт нь, хэдэн хувь нь энэ 29 дүгээр заалтаар зөвлөмжөө авч байгаа вэ. Тэгээд нөгөө төр, хувийн хэвшлийн харьцаа хэд байна. IT-ийн дэмжих хуулийн хэрэгжүүлэх талаар Засгийн газраас, Ерөнхий сайдаас захидлын хариу ирсэн шүү дээ. Тэрний дагуу ямар ажлууд хийгдэж байна. Битгий дахиад асуулгаад бай л даа. Би цагаа бас үлдээж байгаад өөр юм асуумаар байх юм. Тэгээд асуултаа дахиад уншихлаа шүү дээ.

Ч.Анар: Тэр мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар бас асуусан. Тэрийг бас хариулъя. Индрийн микрофон.

Д.Цэнгүүнжав: Сая Худалдан авах ажиллагааны газраас 170 орчим гэж байна. Тэгээд энэ жил 12 гээд бодох юм бол 5, 6 хувьтай дүгнэлт, зөвлөмж авсан гэсэн үг. Тэгэхдээ сая хэлсэн ер нь бол уялдаа холбоог хангах зохицуулалт хийхийн тулд мэдээлэл хэрэгтэй. Мэдээлэл дээрээ бид нар давхардаж байгаа үгүй эсэх энэ бол ер нь хангалтгүй байдаг. Жишээлбэл тэрний бодит жишээ бол энэ дүгнэлт, зөвлөмжийн асуудал. Бүр сүүлдээ худалдан авах дээр нь энийг битгий зарлаж бай гэдэг байдлаар явж байж үр дүн гарч байгаа. Төсөл хөтөлбөрийн ер нь яамнаас уялдаа холбоог нь хангах гэдэг энэ зохицуулалт бол төсөл хөтөлбөр дээр ялангуяа хэрэгтэй байгаад байгаа. Бид нар Эрүүл мэндийн яам, Хууль зүйн яамтай хамтраад ажлын хэсэг гараад явангуут жинхэнэ асуудлуудаа мэдээд, уг нь мэдээлэл байхгүй. Бид нарт ч гэсэн гаднын донор байгууллагуудын уулзалт ирдэг. Бид нар бэлэн төсөл хөтөлбөр байгаа бол санал болгох байтал тусдаа мэдээллээ өгдөггүй ийм асуудал байдаг. Дараа нь бас дэд бүтэц, тоног төхөөрөмж хэрэгтэй гээд байдаг. Гэтэл бид нар дата төв дээр хөрөнгө оруулалт хийчихсэн, нэгдсэн байдлаар тэндээс өгөх боломжтой асуудлууд байхад хүртэл тусдаа зарим газруудтай хөрөнгө оруулалт хийгдэнэ гээд явж байдаг иймэрхүү асуудал хүртэл гардаг. Тэгэхээр уялдаа холбоог яг энэ цахимтай холбоотой бүх асуудлыг яаман дээр мэдээлэл ирж байж бид нар хаанаас дэд бүтцийг нь яаж шийдэх ёстой юм гэдэг ч юм уу нэгдсэн байдлаар ийм төлөвлөлтүүд хийх боломжууд бий болох юм.

Тэгээд тэр төсөв санхүүжүүлэхгүй байх гээд өмнө нь та хэлсэн. Үүрэг өгсөн. Энэ өөрөө бид нар бас шийдэж чадахгүй. Сангийн яам энэ тэр дээр явдаг болохоор ийм уялдаа холбооны хүч нь байхгүй ч гэдэг юм уу, зохицуулалтыг нь хангаж чадахгүй л байгаад байгаа.

Үндэсний зөвлөл дээр сая Ерөнхий сайд Үндэсний зөвлөлийн хурал болоод Мэдээлэл технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний

зөвлөлийн тогтоолоор төлөвлөгөө, гэрээг нь бол баталгаажуулсан. Нөгөө яригдаад байгаа виртуал бүсийн гэрээ байгуулах гэрээ маань албажсан гэсэн үг. Тэгээд энэ хүрээнд бас зөвлөлийн тогтоол 02 дугаартай “Виртуал бусын үйл ажиллагааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” гээд тогтоол гарсан.

Тогтоолоор 1 дүгээрт энэ хууль маань өөрөө олон хууль .../минут дуусав/

Ч.Анар: Гүйцээж хариулъя. Нэмэлт 1 минут.

Д.Цэнгүүнжав: Олон хууль, дүрэм, журамтай бас нийцэхгүй, уялдахгүй байгаагаас болоод хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа. Тэгээд үүний дагуу бол хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахыг сайдад үүрэг болгосон. 4 сарын 21-ний өдрийн тогтоол байгаа.

2 дугаарт нь, ААНОАТ-ын тухай хуулийн 22.6-д заасан жагсаалтад мэдээллийн технологийн виртуал бүсэд бүртгэгдсэн этгээдийн бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт болон гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх мэдээллийн технологийн болон дэвшилтэт технологи, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмж, эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, холбогдох хэрэгслийн жагсаалтыг боловсруулж батлуулахыг үүрэг болгосон. Үүний хүрээнд бол цахим яам ажиллаж байна.

Ч.Анар: Золжаргал гишүүн сүүлийн тодруулга.

Ж.Золжаргал: Энэ мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн салбарт тухайлбал цахим систем болон тэр тоног төхөөрөмж нь зах зээлийн баримжаа байна уу. Хэдэн хувийг нь төрийн худалдан авалт, хэдэн хувийг нь хувийн хэвшил зах зээл дээр явж байна вэ. Цахим системийн тэр дундаа үйлдвэрлэлийн хэдэн хувийг нь үйлдвэрлэл болоод худалдан авалтыг төр хийгээд, хэдэн хувь нь зах зээл дээр компани хооронд явж байгаа юм бэ. Саяын тэр IT дэмжих тухай хууль, Мэдээллийн технологи дэмжих тухай хуулийн хувьд бол нөгөө 40 хувь өөрсдийнх нь төлсөн татварын 40 хувиар буцаагаад дэмжинэ гэсэн тэр 40 хувийн тоо гарсан уу. Хэдэн төгрөг юм тэр нь. Тэгээд Засгийн газрын тусгай сан 3 сан байгаа шүү дээ. 3 сангийн 5 хувиар дэмжинэ гэсэн. Тэрний эрх зүйн зохицуулалт дээр санал бэлтгэгдсэн болов уу.

Ч.Анар: Индрийн микрофон.

Д.Цэнгүүнжав: Гишүүний асуултад хариулъя. Цахим яам Цэнгүүнжав. Ер нь яг тийм бодит тоогоо бас гаргаж чаддаггүй. Цадахгүй байгаа. Ер нь бол мэдээлэл технологийн гээд улсын бүртгэлээс мэдээлэл технологийн ангилалтай гэж компаниудыг нөгөө бүртгэгдсэн компаниудыг ерөнхийгөөр нь аваад, тэгээд 1 тооцож үзэхэд үйлдвэрлэлийн юу бол 20 орчим тэрбум гэсэн тоо байгаа. Тэр сангийн асуудал бол бас яг нөгөө хууль нь уялдаа байхгүй буюу яг энэ сан дээр гаргах гэхээр нөгөө хаанаас гарах нь байдаггүй юм байна лээ. Тэгэхээр энэ хэрэгжилт дээр энэ асуудлууд бүгдээрээ гарч ирэх байх. Яг одоо юу гэдэг юм, үйлдвэрлэлийг дэмжихдээ ийм ийм дэмжлэг сангуудаас гэхихсэн. Тэгэхдээ хаанаас гарах нь бас тодорхойгүй буюу уялдаа холбоо хангалтгүйгээс болоод энэ хууль өөрөө хэрэгжих боломжгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ судалгаа, хэрэгжилтийн үнэлгээгээр бүх зүйл тодорхой болоод гарна.

Үнэлгээг нь саяын тогтоолоор Ерөнхий сайд 4 сарын 21-нд үүрэг өгсөн. Тэгээд ажиллаад явж байгаа гэсэн үг. Хугацаагүйгээр энэ дээр үнэлгээг хий гэж өгсөн байгаа юм.

Ч.Анар: Индрийн микрофон 1 минут.

Д.Цэнгүүнжав: Цахим яам Цэнгүүнжав. Ер нь бол та бүхэн хэлсэн цахим яам буюу хэрвээ бидэнд дата мэдээлэл гаргаад өгчих юм бол энэ харьцаа, бүх тооцоолол гарах боломжтой. Гол асуудал нь мэдээлэл ирэхгүй, мэдээлэл гарах асуудал нь өөрөө тийм байгаа болохоор яг бодитоор гарахгүй. Сая өмнөх тоо бол тэр 20 орчим тэрбум үйлдвэрлэл гэдэг бол тойм төдийгөөр гарсан юм байна лээ. Бид нар тэгээд энэ дээр бас ажиллаж байгаа. Ерөнхийдөө энэ тендер бүх юман дээр авч байгаа компаниудыг бүртгээд ч юм уу яг ийм байдлаар бодит тоогоо гаргадаг болъё гэдэг байдлаар.

Ч.Анар: Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас асуулт асууя. Энэ сүүлийн 2 жил Инновац цахим бодлогын байнгын хороо гэж байхад, Золжаргал гишүүн даргалж байх үед л энэ асуудал яригдаж байсан. Тоогоо нэгтгэж чаддаггүй. Одоо болтол тоогоо нэгтгэж чаддаггүй. Төрийн худалдан авах газрын өгсөн энэ зузаан материалыг эксел хэсэг дээр харахаар 1,8 их наядын төсөвт худалдан авалт хийсэн байгаа. Тэгээд сая нийт төсөл хөтөлбөр нь хэдэн хувийг нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 29.1-ээр зөвлөмжөө авсан бэ гэхээр 5-6 хувь гэж байна. Тэгээд энэ завхрал ерөөсөө шийдэгдэхгүй байна. Тэгээд энэ тоогоо яам нь мэдээллээ авч чадахгүй гээд байдаг. Сангийн яам нь 2 жилийн өмнө мэдээллээрээ хүргэж өгье гэсэн яг тэр хариулттай яг 2 жилийн дараа хариулж байна шүү дээ. Үндсэндээ жил хагасын дараа. Тэгээд төрийн худалдан авах газар 1,8 гээд ерөөсөө тоо таардаггүй. Энэ чинь их тоонууд шүү дээ. Одоо энэ AI, Big data гэдэг гоё үгтэй. Аудит үнэлэлт дүгнэлт хийхэд хэцүү. Төрийн худалдан авалтууд маш их явж байгаа. Энэ бол ер нь завхрал болчихсон. Тэгээд энийг хаана нэгтгэх ёстой юм бэ гэхээр бүгдээрээ бие бие рүүгээ чихээд байх юм. Хэрэг эрхлэх энэ дээр хариулж өгөөч. Хэрэг эрхлэх газар энэ уялдаа холбоог нь хангаж өгөөд, Засгийн газрын үйл ажиллагааг нь хуулийн хэрэгжилтийг биелүүлэх ёстой юм биш үү. Танай дээр яг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн худалдан авалт ямар тоо байгаа вэ. Тэр мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас асууя. Индрийн микрофон.

Б.Билэгдэмбэрэл: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл технологийн газрын дарга Билигдэмбэрэл. Тэгэхээр ер нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн заалт дээр бол Цахим хөгжил, харилцаа холбооны яам бол мэдээллийн системүүдийн бүртгэлийг хийх ёстой. Тэгээд дээр нь нөгөө түрүүний хэлсэн 29.1 дэх заалтаар болоод ирэх юм дүгнэлт, зөвлөмж бол гаргаж өгөх ёстой байдаг. Тэгэхээр Хэрэг эрхлэх газрын зүгээс ер нь энэ системийн бүртгэлтэй холбоотой асуудлыг хэд хэдэн удаа бас тогтоолоор үүрэг даалгавар гаргаж өгч байсан. Тухайлбал, 2025 оны 10 сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлээр бүх төрийн байгууллагуудыг system.gov.mn-д мэдээллийн системийг бүртгэ гэдэг асуудлыг гаргасан. Мөн өнгөрсөн оны бас 12 сард хяналт хэрэгжүүлэх газар дээр яг энэ мэдээллийн системтэй холбоотой тодорхой 5 байгууллага дээр бас хяналт, шинжилгээ, дүгнэлт бол хийж үзсэн байгаа. Тэрнийхээ дагуу 02 дугаар албан даалгаврыг гаргаж, төрийн худалдан авах ажиллагааны газарт заавал энэ дүгнэлт, зөвлөмжийг авсны үндсэн дээр тендер шалгаруулалтын асуудал руу ороорой гэсэн ийм үүрэг даалгаврыг өгсөн. Үүний

дагуу бас тодорхой хяналт тавиад нэхэгдээд явж байгаа. Яах вэ, орон нутгийн хувьд бол Хэрэг эрхлэх газар дээрээс бид мөн мэдээллийн системтэй холбоотой асуудлыг нэгтгэж үзсэн. Тэгэхэд ер нь нийтдээ 352,5 сая төгрөгөөр мэдээллийн систем болон программ хангамжтай холбоотой урсгал зардлын хөрөнгө оруулалт хэлбэрээр бол зарцуулсан байна гэсэн тоо гарсныг албан бичгээр юунд бол хүргүүлсэн. Тэгэхээр ер нь хуулиараа бол тодорхой дүгнэлт, зөвлөмжийг Цахим хөгжлийн яамны зүгээс гаргаж өгөх ёстой.

2-т бол системийн болоод энэ бүртгэлийн асуудлыг Цахим хөгжлийн яам маань бас бүртгээд явж байх ёстой байгаа.

Ч.Анар: Дахиад тодруулъя. Их Хурлаас тогтоол бараг 2 ч гарлаа. Байнгын хорооны тогтоол. Хууль байгаа. Засгийн газраас тогтоол гарлаа. Тэгээд цахим яам нь хэрэгжүүлж чаддаггүй, Сангийн яам нь мэдээллээ өгдөггүй. Шүүж чаддаггүй энэ асуудлыг хэдүүлээ яаж шийдэх вэ. Хууль хэзээ хэрэгжих вэ. Хэн хариулах вэ. Хэрэг эрхлэх хариулах уу, Цахим яам хариулах уу. Цахим яамнаас асуухаар бид нар мэдээллээ авч чадахгүй байна л гэдэг асуудал одоо ингээд 2 жил болж байна шүү дээ. Энэ асуултын хариултыг хэн хариулах ёстой вэ. Хэрэг эрхлэх хариулъя.

Б.Билэгдэмбэрэл: Тэгэхээр тогтоолынхоо юугаар болоод ирэх юм бол үүрэг даалгавар тогтоолд тодорхой үүрэг даалгаврыг хэрэгжүүлж байхад биелүүлэхгүй байгаа холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох тухай асуудал л Хэрэг эрхлэх газраас яригдах ёстой.

Ч.Анар: Сангийн яам тодруулга.

Б.Ганзориг: Анар гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яам Ганзориг. Сая бас та хэллээ. Манай төрийн худалдаа ажиллагааны агентлагаас ирсэн мэдээн дээр 1,8 их наяд гээд Сангийн яамнаас манайхаас явуулсан мэдээлэл бол 1 их наяд гээд түрүүн бас ярьсан. Тэгээд энэ тоо зөрж байгаа гол шалтгаан бол түрүүн би бас хэлсэн. Манайхаас явуулсан мэдээлэл дээр бол төрийн өмчит компани болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудын мэдээлэл бол энэ мэдээлэлд ороогүй. Яагаад гэхээр төрийн худалдан авах ажиллагааны газар дээр маань бүх төрийн өмчит компаниуд, орон нутгийн бас тендер маань бас зарлагдаад, тэгээд tender.gov.mn дээр тавигдаад явж байгаа учраас энэ бас мэдээлэл зөрсөн байх гэж бодож байна.

Мэдээж манай Сангийн яаманд байгаа мэдээллүүд бүх мэдээллүүд нээлттэй ил тод байгаа. Жишээлбэл яг бид нар энэ системийнхээ хүрээнд хөгжүүлсэн rimis.gov.mn гээд систем маань бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа бүх ажлууд нээлттэй байж байгаа. Odamis.mof.gov.mn гээд бас систем маань байгаа. Энэ маань бол гадаад зээл тусламжаар явж байгаа бүх төслүүдийн мэдээлэл нээлттэй байгаа. Тэгэхээр бас энэ нээлттэй мэдээллийг манай цахим яам маань бол өөрсдөө тэр нээлттэй ил тод байдлаа, хуулийн хүрээнд ч гэсэн нээлттэй байгаа учраас энэ мэдээллүүдийг бүрэн авах боломжтой байгаа. Заавал төрийн байгууллагууд хоорондоо албан бичиг тоотоороо харьцах .../минут дуусав/

Ч.Анар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Нэр авъя. Золжаргал гишүүнээр тасаллаа. Ренчиндоржийн Батболд гишүүн.

Р.Батболд: Цахим хөгжлийн яам маань бас л арай л хангалтгүй ажилладаг юм уу даа. Бараг агентлагийн түвшинд л баймаар юм биш үү дээ. Эсвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх хажуудаа авдаг юм уу, яадаг юм. Мэдээллээ авч чаддаггүй, тэгээд бодлогоо явуулж чаддаггүй ийм яам ч байгаад байх хэрэг байна уу, үгүй юу.

2 дугаарт түрүүчийн хурал дээр та хэд бас буруу мэдээлэл өгсөн байна шүү дээ. Одоо сарын 480 доллар олчихоор ийм төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд, бид нар 1500 хүнд хичээл заана гээд байсан. Одоо 6 сарын хугацаанд байхгүй юу гээд тэрийгээ тэгж яриад сууж байдаг. Худлаа мэдээлэл өгсөн байна шүү дээ. Тэгээд 6 сарын хугацаанд гэвэл энэ хүмүүс чинь уурлаад байгаа нь зөв шүү дээ. Олох гэж байгаа орлогоосоо илүү өндөр дүнтэй тендер сургалт гэж юу байдаг юм бэ. Энэ чинь тэрүүгээр нь үржүүлээд үзэхээр 2,6 тэрбум л гарч байна шүү дээ. Тэгээд та нар 7 тэрбумын тендер зарлалтаар бид нар 6 сарын хугацаанд 2,6-г олох гэж байгаа юм гээд ингээд сууж байдаг. Энэ сүүлдээ та нар өөрсдөө хүртэл ийм цахим биш зүгээр тендерийн яам болох юм уу. Энийгээ боливол яасан юм. Энэ ирүүлчихсэн байгаа материалууд дотор та нар өөрсдөө ядаж цахим яам байна даа. Энийгээ буцааж оруулаад байдаг юм уу, Сангийн яам нь ингээд холиод өгчихдөг юм бол эргүүлээд зөвхөн цахим системтэй нь холбоотой нь ийм байна гээд тэгээд ядаж энэ төсвийн ерөнхийлөн ерөнхийлөн захирагч нараар нь ялгаад гаргаад өгчхөж чаддаггүй юм уу. Тэгээд ийм юм өгчхөөд, энийгээ хар гээд ингээд сууж байдаг. Тэгээд энэ дотор ингээд холилдоод 1,8 ч юм уу, 1 их наяд ч юм уу ийм их мөнгөний асуудал яригдаж байхад хариуцлага гэж юм ер нь байхгүй байна даа. Мэдэхгүй, маш сонин юм байна. Энэ яам байх хэрэг байгаа ч юм уу, үгүй ч юм уу. Сүүлдээ ер нь бодоход.

Ч.Анар: Жаргалсайханы Золжаргал гишүүн үг хэлье.

Ж.Золжаргал: Салбарын бодлого хэрэгжүүлэхийн тулд салбарын тоо хэрэгтэй. Одоо бид нарт салбарын тоо байхгүй байна. Саяын тэр их наядар тоологдох юман дотор байшин барилга орсон л гэж байна. Тэгээд хувийн хэвшил дээр хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаа мэдэхгүй байна. Төрийн худалдан авалтаар дэмжиж байна гээд тэр нь их том дүнд хүрээд ингээд яваад байдаг. Нөгөөх нь сүүлдээ салбараа өөрийг нь ингээд устгах, эрүүл зүгээр өрсөлдөөнтэй явж байгаа юмыг аваачиж саяын тэр цахим онлайн хичээлийн жишээ байхгүй юу. Худалдаж аваад, том худалдан авалт зарлаад, нөгөөх нь бизнестээ саад болдог иймэрхүү үзэгдлүүд яваад байгаа юм л даа.

Тийм учраас энд байгаа гишүүд бүгд л байсан. Сүүлийн 2 жил бид нар ингээд шаардаад байгаа юм. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль нь хэрэгжихгүй байна. Хэрэгжүүлээд аль гээд шаардсан байдаггүй. Худалдан авалт нь хуулиараа зөвлөмж авах ёстой. 29 дүгээр заалт. Зөвлөмж аваагүй бол битгий худалдан авалт хий гээд шаардсан. Байдаггүй. Одоо болтол 5, 6 хувь. Ерөнхий сайд нь хүртэл араас нь юм гаргаад хэрэгжихгүй байна шүү дээ. Тэгээд худалдаж авч байгаа юмаа мэдэхийн тулд, хэдэн төгрөгөөр авдгаа мэдэхийн тулд мэдээллийн технологи болоод кибер аюулгүй байдал гэсэн эдийн засгийн ангилал нэмье гэдэг шийдвэрийг Байнгын хорооноос гаргаад өгч байсан. Сангийн яаманд. Тэгээд энэ нь хэрэгжих юм бол хэдэн төгрөгөөр авдаг юмаа арай нэг ялгаж мэдэх юм болов уу.

Нийтийн мэдээллийг олон нийт нь өөрсдөө хэрэглэдэг байх, хувь хүний мэдээллийг нь нууцалж хувиргаад бас 2 жил ярьж байгаа. Байдаггүй. Тэгээд энэ шийдвэрүүд нь гараад байдаг. Улсын Их Хурлаас гаргаж байгаа шийдвэрийг тоохгүй байна. Салбарын яамыгаа нөгөөдүүл нь бас тоодоггүй юм уу, хаашаа юм. Асуухаар л тийшээ бичиг явуулсан, ийшээ бичиг явуулсан, ирдэггүй гээд. Тэгээд тийм

болохоор Ерөнхий сайдад бид нар Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаар асуулга явуулсан шүү дээ. Одоо ингээд өөр өөр тийшээ харчхаад, томроод суугаад байдаг юм байна. Тэгэхээр кабинет дээрээ цуглуулж байгаад шийдвэр гаргаад өгөөч гээд. Тэгээд тэрний араас тогтоол гарсан гэсэн. Тогтоол гараад хэзээ дуусах нь мэдэхгүй судалж байгаа гэсэн. Тэгэхээр яг ийм хариулт ингээд 2 жил болоод явчихлаа. Тэгэхээр уг нь бол энэ салбарыг хөгжүүлэх, дэмжих хэрэгтэй гээд Их Хурлын энэ бүтэц нь ч гэсэндээ тэр салбарын яамаа дэмжээд, ингээд 2 жил шахаад явж байгаа. Тэгэхээр энэ намрын чуулган эхлэх үед энэ асуултуудыг дахиад тавья гэсэн хүсэлтийг Анар даргад гаргаж байна. Хэрвээ хэрэгжихгүй бол бид нар албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлыг яамны удирдлагууд болоод сайдад хариуцлага тооцох асуудлыг ярина. Тэгэхгүй бол энэ ингээд л яваад одоо гуравдагч сайдынхаа нүүрийг үзэж байгаа байдалтай байна.

Нэг их гоё салбар гээд ингээд дэлхийд гарах монголчуудын гарц энэ тэр гээд баахан залуучуудыг хүлээлт үүсгэхээд байгаад байдаг. Тэгээд нөгөөх нь энэ яах вэ, эд нар ингэсхийгээд байж л байг гээд тийм жижиг салбар ч юм уу, салбарынх нь удирдлагууд нь гүйгээд явсан ч гэсэндээ нэг л тоож өгдөггүй амжилт төрдөггүй ийм зүйл байна. Тэгэхээр энэ бол кабинетын түвшинд ярих ёстой асуудал байх. Тэгээд намрын чуулган хүртэл энэ асуудал нь шийдэгдэхгүй бол хариуцлага тооцох асуудал ярих нь зүйтэй гэж бодож байна.

Тэр төрийн нийт худалдан авалтад төрийн өмчийн компаниуд байхгүй, хууль хүчний байгууллага энэ тэр байхгүй гээд байгаа тэр юунуудыг нь тэр хууль хүчний байгууллагынх нь юмыг нууцын ангиллаар авч танилцъя л даа гэсэн саналыг бас би даргад гаргамаар байна. Ерөнхий бид нар бас баримжаа авах хэрэгтэй. Энэ улч чинь хэдэн төгрөгөөр юу худалдаж аваад байгаа юм.

Ч.Анар: Золжаргал гишүүний гаргасан нууцтай холбоотой материалууд байгаа. Та нууцын ажилтанд хүсэлтээ өгөөд, надаас цохолт аваад танилцаж болно.

Энэ мэдээллийн технологийн салбар нь өөрөө хүн болгон л гоё үг, хиймэл оюун ухаан, биг дата гээд ийм том том гоё үгний ард, хуучин бол хөшөө дурсгалын ард төрийн худалдан авалтыг нуугаад, хүний оюуны бүтээлийг үнэлэх боломжгүй гэдэг байсантай адилхан ийм их нуултууд хийчихсэн байгаа. Энийг бол Инновац, цахим бодлогын байнгын хороо гэж байх үед бид нар 2024 оноос хойш 1 жилийн хугацаанд бүгдтэй нь танилцсан. Зарим томоохон хөтөлбөрийг 20 сая төгрөгөөр хийж байна буюу хэрэгжих боломжгүй. Зарим үнэхээр 20 сая төгрөгийн хөтөлбөрийг 2 тэрбумаар хийж байгаа асуудлуудыг харсан. Мэргэжлийн хүмүүсийн хувьд. Тэгэхээр энэ хууль хэрэгжүүлэхтэй холбогдолтой Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дүгээр заалтыг хэрэгжүүлж байж энэ асуудал цэгцрэх юм.

Монгол Улс өөрөө цахим хөгжил дээрээ бол харьцангуй үсрэлттэй явж байгаа. Гэхдээ яг энэ үсрэлтийн цаана завхрал явагдах гээд байна. Тоо 1,8 их наяд, 1 их наядынхаа цаад ялгаагаа ч гаргаж чадахгүй болчихсон. Ард, олон нийт болоод шийдвэр гаргагч нар нь энэ олон гадаад нэр томъёоных нь цаана нь хяналт хийж чадахгүй асуудал үүсчихсэн байгаа. Тэгээд энэ хуулийг хэрэгжүүлэх гол үүрэг нь цахим яаман дээр байдаг. Цахим яаман дээр нь Байнгын хорооны тогтоол гаргаж дэмжлээ. Засгийн газар нь тогтоол гаргаж дэмжлээ. Тэгээд хэрэгждэггүй.

Тэгэхээр Их Хурал бол хууль тогтоох хэрэгжүүлэхэд хяналт тавих чиг үүрэгтэй. Тэгэхээр энэ чиг үүргийнхээ дагуу бол Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо цаашид хяналт тавьж ажиллах ёстой гэж үзэж байна. Энэ хуулийг хэрэгжтэл нь энэ дэд хороо ажиллана. Хуулиа хэрэгжүүлээд, бүх төрийн худалдан авалтууд цахим яамнаас саналаа авдаг болоод, нэгтгэсэн дүнтэй, бодит өртөгтэй, цаана нь ноогдохгүй байх дээр Үндэсний аудит, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, бусад төрийн бүх яам чиг үүргүүд хамтарч ажиллах ёстой. Энэ дээр нь Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны гишүүдийн гаргасан саналын дагуу бид бол ажлын хэсэг гаргаж ажиллая.

Тэгэхээр энэ 2 жилийн хугацаанд тогтоол гаргаад болохгүй бол одоо бүгдээрээ нийлж байгаад энийг бодит ажил хэрэг болгох дээр ажиллахаас өөр арга үлдсэнгүй гэж үзэж байна.

Өнөөдрийн хэлэлцэх 1 дүгээр асуудал дууслаа.

14.34 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ